


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-40 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1635** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1635 тохиолдлын 95% /1554/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /81/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **450** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **40** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.09.28 – 10.04)

2025 оны эпидемиологийн 40 дүгээр долоо хоногт 23 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 64.6 хувиар, 5 жилийн дунджаас 58.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-40 дүгээр долоо хоногт нийт 1054** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


610Эмнэлэгийн
тусламж авч буцсан**444**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
47%Эмэгтэй
53%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 40 дүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **25** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 7.4 хувиар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 66.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 40 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	9	10
2	Эмийн хордлого	4	11	15
Нийт		5	20	25

Нийт 25 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 20 буюу 80% нь санамсаргүй, 5 буюу 20% нь санаатай хордлого байна. Эмийн хордлого 15 тохиолдол буюу нийт хордлогын 60%-ийг эзэлж, хордлогын хамгийн өндөр хувьтай байна. Харин химийн бодисын хордлого 10 тохиолдол буюу 40%-ийг эзэлжээ. Энэ нь хүн амын дунд эмийн буруу хэрэглээ, хяналтгүй хэрэглээ илүү түгээмэл байгааг илтгэж байна.

-oOo-